

ХҮҮХДЭД БАГА НАСНААС НЬ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТАНИН МЭДҮҮЛЭХ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ (ЯПОН УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР)

INFORMING CHILDREN ABOUT SAFETY FROM AN EARLY AGE: AN ANALYSIS OF SCHOOL CURRICULUM COMPARISON WITH JAPAN

Н.Өнөржаргал

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч*

Товч агуулга: Хүүхэд гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг учраас хүүхдэд бага наснаас нь аюулгүй байдлын талаар мэдээлэл өгөх, сануулах, сэрэмжлүүлэх сургалтыг өргөн хүрээнд, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай байна. Манай улсын хувьд бага, дунд ангийн хүүхдүүдэд аюулгүй чиглэлийн хичээл сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгагдсан талаар судалгаа хийж, Япон Улсын бага, дунд ангийн сурагчдад заадаг сургалтын хөтөлбөртэй харьцуулан дүгнэлт, санал боловсруулав.

Abstract: Young children are at high risk of becoming victims of crime. Therefore, it is necessary to give children information, reminders, and warnings about safety from an early age. In our country, we conducted a study on how safety lessons are included in the curriculum for elementary and middle school children, and compared it with the curriculum for elementary and middle school children in Japan.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх, үүрэг, хариуцлага, хичээлийн хөтөлбөр.

Keywords: Safety, prevention, duties, responsibilities, curriculum.

Удиртгал

Монгол Улсын Засгийн газраас 1992-2002, 2002-2020 онд “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах нь үндэсний хөтөлбөр”-ийг, 2012-2015 онд “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх нь стратеги”-г хэрэгжүүлсэн ба хөтөлбөрийн ололт амжилт, сургамж, туршлагадаа үндэслэн 2017-2021 онд хэрэгжих “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж байна.⁶⁸ Тус хөтөлбөрийн 3.1.2.1.ерөнхий боловсролын сургууль (Цаашид “ЕБС” гэх)-ийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг тусгах, 3.2.1.3.хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, 3.4.1.1.хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх, түүнд учрах эрсдэл, хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг”-ийг баталж мөрдүүлэх зэрэг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 5 бүлэг 15 дэд бүлгийн хүрээнд хүүхэд хөгжүүлэх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрүүл мэндийн чиглэл бүхий зүйл, заалтыг тусгажээ.⁶⁹

Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчин сайжирч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, 108 утас, түр хамгаалах байр, хүчирхийллийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажиллаж байгаа ч тулгамдаж байгаа асуудал байсаар байна. Гэмт хэрэгт өртөж байгаа, хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдүүдийг цаашид хэрхэн яаж хамгаалах, хүүхдүүдийг гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх нь хамгийн зүй зохистой арга юм.

⁶⁸ Үндэсний статистикийн хороо. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. УБ. 2018.

⁶⁹ Монгол Улсын Засгийн газрын тогтоол. №270. Үндэсний хөтөлбөр батлах тухай. УБ. 2017.

Үндсэн хэсэг

Улсын хэмжээнд 2022 оны эхний хагаст гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 12.411 байснаас 808 (6.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд, гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2022 оны эхний хагас жилд 20.000 болж, 1.154 (5.8%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.⁷⁰

Цагдаагийн байгууллагаас 2021 онд хүүхэд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдын эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тэдэнд хариу хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал”, “Хичээл эхэллээ” “Нуугдмал” зэрэг дөрвөн ерөнхий арга хэмжээ, 320 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан.⁷¹

ЕБС-ийн 1-6 дугаар ангид иргэний боловсрол, хүн ба орчин, монгол ёс хүмүүжил, хүн ба нийгэм, эрүүл мэнд, иргэний ёс зүйн боловсрол зэрэг ёс зүй, монгол уламжлал, харилцаа хандлагын талаарх хичээлүүд ордог ба эдгээр хичээлүүдэд аюул тулгарсан үед хэрхэн өөрийгөө хамгаалах, гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөх эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх хичээл байхгүй байна. ЕБС-ийн 1-5 ангийн хичээлийн агуулгад аюулгүй байдлын талаар орсон хичээл нь 2.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт №1. ЕБС-ийн 1-5 дугаар ангийн хичээлүүдийн агуулгын эзлэх хувь.

ЕБС-ийн 1-5 дугаар ангийн хичээлүүд					
Хичээлийн агуулга	Иргэний боловсрол	Хүн ба орчин	Хүн ба нийгэм	Монгол ёс хүмүүжил	Дундаж хувь
Монголын уламжлалт ёс, заншил	50.0	0.0	0.0	30.0	20.0
Харилцаа	13.0	7.0	27.0	55.0	25.5
Үүрэг, хариуцлага	19.0	5.0	7.0	0.0	7.8
Аюулгүй байдал	3.0	0.0	5.0	0.0	2.0
Дүрэм журам	11.0	5.0	14.0	0.0	7.5
Танин мэдэх	4.0	83.0	47.0	15.0	37.3
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

6 дугаар ангиас эрүүл мэндийн хичээл болон иргэний ёс зүйн боловсрол зэрэг хичээлүүд нэмэгдэж орж байгаа ба дээрх хичээлүүдийн 26.7 хувь нь Монголын уламжлал, ёс заншлын талаар, 34.7 хувь нь танин мэдэхүйн агуулгатай байгаа бол дараах 3 хичээлийн хүрээнд аюулгүй байдлын талаар заасан хичээлийн агуулга 1.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт №2. ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн хичээлүүдийн агуулгын эзлэх хувь.


ЕБС-ийн 6-9 ангийн хичээлүүд				
Хичээлийн агуулга	Иргэний боловсрол	Эрүүл мэнд	Иргэний ёс зүйн боловсрол	Дундаж хувь
Монголын уламжлалт ёс, заншил	50.0	0.0	30.0	26.7
Харилцаа	15.0	3.0	24.0	14.0
Үүрэг, хариуцлага	21.0	16.0	23.0	20.0
Аюулгүй байдал	3.0	0.0	0.0	1.0
Дүрэм журам	11.0	0.0	0.0	3.7

⁷⁰ https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Crime_2022_I-VI_mn.pdf&ln=Mn-aac үзэв.

⁷¹ 2021 онд 921 хүүхэд гэмт хэрэг үйлдэж, 1.365 хүүхэд хохирсон дүн мэдээтэй байна. Эх сурвалж: Eguur.mn.


Танин мэдэх	0.0	81.0	23.0	34.7
Нийт	100.0	100.0	100.0	100.0

Зураг №1. ЕБС-ийн 1 дүгээр ангийн иргэний боловсрол хичээлийн агуулга.



Хичээлийн агуулга нь зурган хэлбэрээр бага ангийн хүүхдүүдэд ойлгоход хялбар боловч ихэнхдээ монгол ёс заншил үүрэг хариуцлагын талаар түлхүү заасан ба аюултай зүйл тааралдвал хэрхэн сэргийлэх талаар зураг, хичээл байхгүй байна.

Зураг №2: ЕБС-ийн 4 дүгээр ангийн хүн ба нийгэм хичээлийн агуулга, хэлбэр.



4 дүгээр ангийн хичээлийн агуулгад гэр бүл, гэр бүлийн гишүүдийн эрх үүрэг, 5-р ангийн хичээлд гэр бүлийн гишүүдийн харилцаа зэрэг сэдвүүд орсон байна.

Зураг №3. ЕБС-ийн 6 дугаар ангийн иргэний боловсрол хичээлийн агуулга, хэлбэр.




“Амьдрах хүч, чадал” хичээл нь маш өргөн хүрээний агуулгатай ба хичээл бүр нь өгүүлэмжийг уншаад ойлгосноо ярилцах, буруу зөв талаар ярилцан дүгнэлтэд хүрэх зарчмаар явагддаг. Дээрх өгүүлэмж нь “Аюултай шүү” гэсэн гарчигтай байна.

- Танихгүй ах замд дэлгүүр орох зам асуув;
- Тэр их сайхан зантай ах байв;
- Гэхдээ ээж танихгүй хүний машинд сууж болохгүй, танихгүй хүнийг дагаж явж болохгүй гэж хэлсэн;

Танихгүй ах машинд суугаад зам заагаад өгөөч гэж хэлсэн;
 - Би ээжийн үгийг санаж байсан боловч за гээд хэлчихсэн;
 - Багш: За одоо бүгдээрээ бодоцгооё;
 - Би яагаад энэ ахад итгээд за гээд хэлчихвээ, би аюулгүй байдлын тухай өдийг хүртэл юм бодож байваа, гэх мэт асуултыг тавьж хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлдэг. Дээрх өгүүлэмжээс гадна амьдрах хүч чадал хичээлийн агуулгад амь насны үнэ цэнэ, Ханагийн нулимс, хэрхэн сэргийлэх вэ? зэрэг гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх өгүүлэмжүүдийн хүрээнд ярилцаж хүүхдүүдэд бага ангиас нь ойлголтыг өгдөг байна.

Япон Улсын дунд ангийн хүүхдүүдийн хичээлийн агуулга: Дунд ангийн хичээлд эрүүл мэнд, биеийн тамирын боловсрол, англи хэл зэрэг хичээлүүд нэмэгддэг ба эрүүл мэнд, биеийн тамирын боловсролын хичээлийн агуулгад гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар хичээлүүд ордог. Жишээ нь:

Зураг №5. Дунд ангийн 1 дүгээр ангийн эрүүл мэндийн хичээл, гар утас, сошиал хэрэглээний талаар.



Хичээлийн агуулга нь гар утасны хэрэглээний талаар болон танихгүй хүнээс ирсэн зурваст харихгүй өгөхгүй байх, уншихгүй шууд устгах талаар заадаг ба хариу бичсэн тохиолдолд хэрхэн аюулд учирч болох талаар ярилцдаг байна.

Дүгнэлт

ЕБС-ийн 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн хичээлийн хөтөлбөр, хичээлийн агуулгад гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх хичээл, хичээлийн агуулгын талаарх баримт бичгийн судалгааны үр дүнгээр аюулгүй байдлын талаар заасан хичээлийн агуулга 2.0 хувийг эзэлж байна.

ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн хүүхдүүдийн хичээлийн хөтөлбөр, хичээлийн агуулгад аюулгүй байдлын талаарх агуулга 1.0 хувийг эзэлж байна. ЕБС-ийн 1 дүгээр ангиас эхлэн иргэний боловсрол, хүн ба орчин зэрэг хичээлүүдийг орж байгаа боловч энэ нь Монголын уламжлал ёс зүй, харилцаа хандлага, үүрэг хариуцлагын талаарх хичээл түлхүү орж байгаа ба хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаарх хичээл байхгүй байна. Хэдийгээр хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах нь эцэг, эх, багш, томчуудын үүрэг хариуцлага боловч хүүхэд бага наснаасаа ойлголттой болсноор урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалагдах болно.

Монгол улсын бага, дунд ангийн хичээлийн агуулгыг Япон улсын бага, дунд ангийн хичээлийн агуулгатай харьцуулан судлахад, Япон улсад хүүхдийг 6 наснаас нь буюу 1 дүгээр ангид орох үеэс хичээлийн агуулга хөтөлбөрт, амьдрах хүч чадал хичээлийг оруулж тус хичээлээр, танихгүй хүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл, гэмт халдлага, аюулд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар хичээлүүдийг ордог байна.

Хүүхдэд бага наснаас ойлголтуудыг өгснөөр хүүхэд хариуцлагатай, ухамсартай болж хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэгдэхээс гадна, нөгөө талаар хүчирхийлэгч болохоос мөн адил сэргийлдэг байна.

Японы бага, дунд, ахлах ангийн сурагчдаас, эцэг эхээс, багш нараас улирал тутам хүчирхийлэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх санал асуумжийг бөглүүлдэг. Энэ нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг илрүүлэх, эрсдэлд өртөх магадлалтай байгаа хүүхдүүдийг илрүүлэх зорилготой байдаг байна. Мөн дунд ангийн хичээлээр гар утас, сошиал хэрэглээ, сошиал гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх хичээлүүдийг орж байна. Япон улсад хүүхдүүдийг бага наснаас нь өөрийгөө хамгаалах, хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг мэдээллийг олгож хүүхдийн хүмүүжилд онцгой анхаарч байна.

Санал

Гэмт хэрэг, хүчирхийлэл гарсны дараа арга хэмжээ авах биш, урьдчилан сэргийлэх, хүүхдүүдийг хохирогч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй ба дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- ЕБС-ийн бага ангийн 1 дүгээр ангиас эхлэн аюулгүй байдлын талаар, аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх ойлголтыг "Хүн ба орчин", "Иргэний боловсрол" хичээлийн агуулгад оруулах;

- ЕБС-ийн дунд ангийн сурагчдын гар утасны хэрэглээ, сошиал хандалтын талаарх судалгааг сар бүр гаргадаг байх;

- Сошиал гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар, өөрийгөө эрсдэлд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмжийг хичээлийн агуулгад тусгаж оруулах;

- Гэр бүлийн харилцаа, эцэг эх болох, үүрэг хариуцлагаа хэрхэн ухамсарлах, гэр бүл үр хүүхдээ хүчирхийлэл гэмт хэрэгт өртөхөөс хэрхэн яаж урьдчилан сэргийлэх талаарх хичээлийг оруулдаг байх;

- ЕБС-ийн сурагчдаас сар бүр хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж судалгаа авдаг байх;

Ашигласан материал

1. Үндэсний статистикийн хороо. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. УБ. 2018.
2. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. №270. Үндэсний хөтөлбөр батлах тухай. УБ. 2017
3. 1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Crime_2022_IVI_mn.pdf&ln=Mn-aac үзэв.